



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/618

Мөрөн сум

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар  
хэрэгжиж буй зарим төсөл арга  
хэмжээг зогсоох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20, 14.2.2, 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01 өдрийн ээлжит XIII хуралдааны 04 дүгээр тогтоол, 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн XXVIII хуралдааны XXVIII/37 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/614 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн саналыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөвт өртөг нь өндөр, тухайн жилийн санхүүжилт нь бага, үр дүн муутай, тендер шалгаруулалтыг удаа дараа зарласан боловч сонирхогч этгээд оролцоогүй зарим төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зогсоож, хавсралтаар баталсугай.

2. Тендер шалгаруулалтыг зогсоосон төсөл арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу олон нийтэд мэдээлэхийг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Гансүх), аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсорогдог) нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Гандэлгэр)-д даалгасугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР